

АМАГАЕВ МАТВЕЙ ИННОКЕНТЬЕВИЧ

Гончигийн Ариунболд

БХИС-ийн БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Түүхийн ШУ-ны Магистр

Өгүүллийн товч утга: XX зууны үеийн 20-30-аад оны Монгол дахь Коминтерний төлөөлөгч асан Амагаев Матвей Иннокентьевичийн намтар.

Түлхүүр үг : Түүхэн хүн судлал /биографи/, Амагаев Матвей Иннокентьевич, МАХН-БХК/б/н, МАХН-Коминтерний харилцааны түүх.



**Амагаев Матвей
Иннокентьевич**

Буриадын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, дорно дахиныг судлагч, эдийн засагч, улс төр судлаач Матвей Иннокентьевич Амагаевын талаар монголын XX зууны 20-30-аад оны үеийн талаархи түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн нь цөөн бус байх ажээ...

Энэ хүний амьдрал, намтарын тухай монголын түүхэнд тэр бүр бичиж судалсангүй гэлтэй...

Амагаев М.И нь харь гаралт Бэлчирийн захиргааны Доод Наймагуудын улсын чинээлэг тариачны гэр бүлд 1897 онд төрсөн ажээ.

Зарим талаар Амагаевын талаар манай түүхэнд “социализм”-ын үед харьцангуй бага судлагдсан, мөн ардчиллын он жилүүдэд үндэсний ухамсрын хүрээнд түүний монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ролийг илүү эрс шүүмжлэлтэй талаас нь авч үзсэн бөгөөд XX зууны 20-30-аад оны үед МАН-ыг МАХН болгон өөрчлөх хийгээд Коминтерний албан ёсны төлөөлөгчийн хувьд МАХН дахи “үндэсний ардчилсан” үзэлтнүүдийн эсрэг, сөрөг байр суурь баримталж, “хөдөө”-гийнхэн буюу хожмоо “зүүнтэн”-ий байр суурийг баримтлах болсон Ө.Бадрах, П.Гэндэн, З.Шижээ, Л.Лааган нарын зэрэг хүмүүсийн үзэл санааг дэмжин, “большевик” үзэл суртлыг монголд дэлгэрүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн одоогийнхоор бол “сөрөг”, мөн үеийнхээр ардын хувьсгалын анхны зүтгэлтэн “ээрэг” эрхэм хэмээн тус тус үзэж ирсэн бөгөөд одоо ч мөн адил үзэж буй ажээ.

Энэ талаар манай түүхчидээс Ч.Лонжид, О.Батсайхан, Д.Дашдулам, Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа, Н.Хишигт, Ц.Батбаяр зэрэг олон түүхчид шүүмжлэлтэй байр сууринаас шүүн хандаж ирсэн байх юм. 1997 онд Амагаевын 100 нас сүүдэр гийсний түүхт ойг Буриадад өргөн дэлгэр тэмдэглэж байлаа...

Түүний талаар буриадын хувьд бол “...Матвей Иннокентьевич Амагаев нь, төр хийгээд нийгмийн нэрт зүтгэлтэн мөн. Тэр богинохон болов чиг хурц тод

амьдралаар амьдарч ирсэн байх бөгөөд овогцсон өрнүүн их үйл явдлаар дүүрэн амьдралыг туулан өнгөрүүлсэн ажээ. Тэр иргэний дайн, буриадуудын үндэсний автономын төлөөхи тэмцэл хөдөлгөөн, Монголд өнгөрүүлсэн он жилүүд, эрдэм шинжилгээ - зохион байгуулалтын он жилүүд, мөн бусад олон олон зүйлүүдийг энд дурьдаж болмуй. Энэ хэсэгт Амагаевын Монгол дахи он жилүүд болон ялангуяа ЗХУ болон Монголын хоорон дахь харилцааны шийдвэрлэх цаг үеийн талаар товч дурьдсу¹....

Буриадын тариачны хөвгүүн М.И.Амагаев нь 1916-1917 оны V “май” сар хүртэл Эрхүүгийн шашны семинарт суралцан дүүргэжээ. Тухайн үедээ Оросын Ажилчны Социал Демократ Намд элсэн орж, большевик болж, хувьсгалын үзэл санаагаар цэнэглэгдэн, энэ бүхэн түүний цаашдын хувь заяаг шийдвэрлэсэн ажээ. Иргэний дайны үед Манжуурт намын нууц даалгавраар ажиллаж байлаа.

1918 онд Сибирийн Төвийн Гүйцэтгэх Хорооны зааварлагч, хэд хэдэн тулалдаанд гар бие оролцжээ. 1920 онд аймгийн гүйцэтгэх захиргааны дарга, дараа нь Буриадын Намын Төв Хорооны орлогч даргаар сонгогджээ. 1921-1922 онд Читад ажиллах болж, Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын засгийн газарт ажиллах болов.

Буриад-Монголын автономит мужийн захиргааны тэргүүлэгчдийн дарга /1922/, Алс Дорнодын Бүгд Найрамдах Улсын үндэсний хэрэг эрхэлсэн сайдаар /1922/, Буриад-Монголын Автономит Бүгд Найрамдах Улсын Төвийн Гүйцэтгэх Хорооны анхны даргаар /1923-1924/ нь тус тус ажиллаж байв.

Байгалийн хязгаар нутгийн түүх судлалын нийгэмлэг, Доржи Банзаровын нэрэмжит Буриад-Монголын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн үйл ажиллагаанд оролцож байжээ. Мөн “Буриадын амьдрал” сэтгүүлийн эрхлэгчээр ажиллаж байжээ.

Амагаев Монголд улс орны хүнд бэрх он жилүүдэд ирсэн. 1924 оны V сард Богд гэгээнийг нас барсны дараахан улс оронд Бүгд Найрамдах засаглал тогтож, XI сард Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхаглан зарлаж, Улсын анхдугаар Их Хурал анхны Үндсэн хуулийг батлан гаргажээ. МАХН-ын III их хурал (1924 оны VIII сард) хөрөнгөтний бус хөгжлийн замаар хөгжихөөр сонголт хийсэн билээ.

Монгол нь Зөвлөлт Орос Улс хийгээд Коминтернтэй харилцаа хөгжүүлж байлаа. Нэг чухал асуудлуудын нэг нь эдийн засгийн хөгжлийн асуудлууд байв, энэ талаар хийж амжуулах ажлууд асар их байжээ. Үндсэн салбар болох – мал аж ахуйг хөгжүүлэх, аж үйлдвэрийг байгуулах, орчин үеийн тээврийг буй болгох, зэрэг зорилтууд тулгарч байсан юм. Мөн үндэсний худалдааг бэхжүүлэх, санхүүгийн тогтолцоог эмх замбараатай болгох, гэх мэт зорилтууд ч байв. Эдийн засгийн бодлогыг бодитойгоор хэрэгжүүлэхэд засгийн газрын оролцоо - Амагаевын оролцоо зайлшигүй байсан ажээ. Ялангуяа, тэрбээр мөнгөний бодлого, санхүү төсвийн бодлого, татварын бодлогыг хэрэгжүүлэхэд их хүчин чармайлт гаргажээ.

1924 онд Монголын худалдаа-аж үйлдвэрийн банк байгуулагдаж, энэ бүхэн нь зөвхөн эхлэл төдий байжээ. Ээлжит асуудал нь мөнгөний шинэтгэл байлаа.

¹ С.К.Рощин., “М.И.Амагаев: годы в Монголии”, “Восток”, Москва., 2000.

Түүний зорилго нь төгрөгийг үндэсний валют болгон эргэлтэд оруулах явдал байв. Тэр нь яваан даа төлбөрийн цорын ганцхан хэрэгсэл болох ёстой байлаа.



Зураг дээр зүүн гараас : Жигжиджав, П.Гэндэн, М.И.Амагаев, Ө.Бадрах нар МАХН-ын VII их хурлын үеэр дурсгалын патер татуулсан бололтой. Улаанбаатар хот. 1928 он.

Ингэснээр гадаадын валютыг түлхэн гаргах зорилт тавигдаж байв. Бэлтгэл ажлууд 1925 оны эхээр эхэлж, гадаадын мөнгөн тэмдэгтүүдийг шахан гаргажээ. Мөн үед Амагаев Монголд ирсэн бөгөөд 12-р сард төгрөг эргэлтэд орсон байна. Үндэсний валютыг эргэлтэд оруулсанаар төсвийн шинэтгэл явуулах ажлыг хөнгөвчилсэн. Тэр нь нэгдсэн төсвийн тогтолцоог буй болгоход чиглэгдсэн байсан бөгөөд Бүгд Найрамдах Улсын төсвийг өөртөө багтаасан байв.

Засгийн Газрын мэдэлд орон нутгийн төсөв байсан бөгөөд түүнийг нь аймгийн захиргааны байгууллагуудад зарцуулах эрх мэдэл нь байжээ. Мөн орлогын эх үүсвэрүүдийг тодорхойлж, зарлагын хэм хэмжээний дүрмийг нь тогтоодог байв¹. Нэгдсэн татварын хуульд тулгуурлан татварын тогтолцоонд өөрчлөлт оруулж, хүн амын чинээлэг хэсэгт өсгөн (нэмэгдүүлэх) татварын хуримтлалын хамаг хүнд нь ноогджээ. Гаалийн шинэчлэл хэрэгжиж - оруулж ирүүлж буй болон гаргаж буй бараа таваарт харилцан ялгавар бүхүй гаалийн татварын хэм хэмжээг ноогдуулж байлаа. Мөн гадны татвараас төсөвт оногдох хувь өсч байлаа. М.И.Амагаев Эдийн Засгийн Зөвлөлийг 1927 оны XI сард тэргүүлжээ. Тэрбээр сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх цаг хугацааг ч олж чаддаг нэгэн байсан бөгөөд "Монголын аж ахуй" сэтгүүлийн дугаарыг бэлтгэхэд гар бие оролцдог байлаа. Сэтгүүл (1926 оноос) хэвлэгдэн гарсанаас

1. Болдбаатар Ж., Түүх зулсан он жилүүдийн ойллого.УБ.И боть., 2003. 41 дэх тал.

эхлэн түүний редакцийн гишүүнээр ажиллах болсон юм. Мөн тэрбээр буриадын хэвлэлүүдтэй ч хамтран ажиллаж байжээ. 1925 оны 2 дахь хагасаас эхлэн М.И.Амагаевын санаа тавих олон тооны зүйлүүдийн дотор бас нэгэн үүрэг нэмэгдсэн явдал бол, хамгийн хүнд хэцүү бөгөөд хариуцлагатай алба болсон нь – тэрбээр МАХН-ын ТХ-ны дэргэдэх Коминтерний Гүйцэтгэх Хорооны бүрэн эрхт төлөөлөгчийн алба хаших болсон явдал юм. Түүний өмнө энэ албыг Турар Рыскулов 1925 оны VII сарыг хүртэл хашиж байгаад МАХН-ын ТХ-ны хүсэлт ёсоор Москва руу буцах болсон юм.

Москвагаас Улаанбаатар руу шинэ хүн олж илгээх хэрэггүй, хангалттай тохирох хүн тухайн газар дээрээ ажиллаж буй : энэ бол Амагаев – хашир туршлагатай намын ажилтан, улс төрч, аж ахуйн ажлын ихээхэн туршлагатай, монголын удирдлагатай ажил хэргийн хэвийн харилцаа холбоотой, мөн хэлний талаар бэрхшээлгүй хүн гэж үзжээ. Товчоор хэлбэл, Москвад, түүнийг амар хялбар бус алба болох Коминтерний нэр нөлөөг МАХН-д хүчтэй болгоход нөлөөлж чадах, энэхүү албыг хаших бүрэн чадвартай хүн хэмээн үнэлжээ.

Шинэ алба үүрэг Амагаевыг бүхэлд нь эзэмдэх болсон гэлтэй. М.И.Амагаев үйл явдлын төв дунд нь онц хүнд нөхцөл байдалд орсон байсан гэлтэй... хэмээн оросын монголч эрдэмтэн С.К.Рощин үзсэн нь буй. 1926-1928 оныг “баруун хэлбэрэл”-ийн ид цаг үе хэмээн үзэж байлаа.

Үнэхээр энэ он жилүүд “монголын үндэсний ардчилалын хөгжилт”-ийн “цаг үе” байжээ. Монголын тухайн цаг үеийн удирдагчид (Ц.Дамбадорж, Н.Жадамба, Б.Цэрэндорж, болон бусад) улс орныхоо онцлог байдал, ирээдүйн чиг хандлагыг харгалзан үзэхийг зорьж байсан хэдий ч, улс төрийн дотоод бодлого доо харьцангуй зөөлөн, аядуу намдуу, болгоомжтой арга бодлого хэрэглэн, улс орноо хязгаарлагдмал гадаад байдлаас гаргах гэсэн, гадаад харилцааг өргөтгөх, гэхдээ эн тэргүүнд Зөвлөлт Холбоот Улстай харилцах харилцаанд нэгдүгээр зэргийн тэргүүн ач холбогдол өгч байсан ба монголын удирдлагын зарим үйлдэлүүд нь “барууны” чиг хандлагатай, хөрөнгөтний бус хөгжлийн замаас ухарсан хэмээн үнэлэгдэх болсон байжээ... Москва болон Улаанбаатарын хооронд /эвдрэл –зох./ хагарал аажим аажмаар өсөн өргөжсөн нь яваан даа зөрчилдөөн үүсэх шалтаг шалтгаан нь болжээ¹ ...

“... Коминтерны заавраар хэрэгжүүлж намын зүүн жигүүрийн ажил явуулгын эхэн үед хувьсгалын ардчилсан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэвшилттэй зүйл цөөнгүй байсныг дурдах хэрэгтэй...”

Коминтерний төлөөлөгч Амагаеваас 1927 онд Коминтерний Гүйцэтгэх Хороонд мэдэлэх дээ Монголын нам төрийн удирдлага, албагн хаагч сэхээтний дотор байгаа үзэл санааны зарим нэг зөрөө ажлын алдаа эндэгдэл зэргийг шүүрэн авч хөдөөгийнхөн хотынхон, хөгшин, залуу гэж дөрөв ангилж тодорхойлоход хамгийн идэвхтэй хэсэг нь хөдөөгийнхөн гэжээ. Тэрхүү зөрөөг Коминтернээс ашиглан дэвэргэж МАХН-ын VI их хурлаас Монголд барууны хэлбэрэл гарав хэмээн сүр бадруулан зарлав. Тэдний үзсэнээр барууны хэлбэрэл гаргагчид нь хотынхон буюу хуучин түшмэдүүд хөгшчүүд, намын зөв журмыг бармтлагчид нь хөдөөгийнхөн буюу залуучууд болжээ. Тэр үеэс

¹ С.К.Рощин., “М.И.Амагаев: годы в Монголии”.., “Восток”., Москва., 2000.

Коминтерн хөдөөгийнхөн, залуучуудыг дэмжих бодлогыг илэрхий явуулж Намын VI их хуралд оролцсон Коминтерний төлөөлөгч Шотманыг хөдөөгийнхнийг олигтой дэмжсэнгүй хэмээн зэмлэж байв ...”².

С.К.Роцины тэмдэглэснээр бол : “... Монголын удирдагчидыг ойр дотно мэдэх Коминтерны бүрэн эрхт төлөөлөгчид энэ нөхцөл байдалд өөрийн байр суурийг тодорхойлоход хүнд бэрх байсан ч, тэдэнтэй харьцах түүний харьцаа хүндэтгэсэн, нөхөрсөг дотно (эхэн үе дээ – зох.) байсан бөгөөд тэдний улс төрийн талаар хараат бус байх гэсэн, үндэсний биеэ даасан, бүрэн эрхт байдлаа хадгалах гэсэн чин эрмэлзлэлийг ойлгон хүлээж авч байсан нь мөн анзаарагддаг...” гэсэн нь монголын судлаачийн хувьд анхаарал татах зүйл юм.

...Үүний нэгэн жишээ бол тэрбээр 1926 оны IV сарын 14-нд бичсэн нэгэн захидал даа дурьдах даа : “...Манай зааварлагч нар Монгол дахи үндэсний өвөрмөц нөхцөл байдлыг тэр бүр ойлгодоггүй, шаардлагатай, уян хатан бөгөөд тэвчээртэй байдлыг үзүүлдэггүй, монголчуудад буруу арга барилаар ханддаг, - дарамтлах, захиргаадах гэх мэт аргаар ханддаг. Үүнээс л чухам хэт үндэсний үзэл санаа төрөн гардгийг анхарах шаардлагатай ...”¹ гэж байжээ. Мөн үүний хамт “...Амагаев сахилга бат бүхүй, шудрага намын гишүүний хувьд өөрийн эрхэлсэн албан даа Коминтерний заавар зөвлөлгөөг удирдлага болгож, ЗХУ дахи намын дотоод дахи зөрчил тэмцлийг зүй ёсоор харгалзан авч үзэх хэрэгтэй байсан гэлтэй ...Тийм дээ ч юуны өмнө, субъектив үүднээс ч мөн адил “баруунтны завхрал”-тай тэмцэх явдал нь өөрийн эрхэм үүрэг хэмээн ухамсарлаж ирсэн бололтой ... Энэ бол тухайн түүхэн цаг үеийн өвөрмөц онцлог гэдгийг судлаач би вээр үгүйсгэхгүй байна ... 1925 оны сүүл үе, 1926 он бүхэл дээ, үндсэн дээ харьцангуй нам тайван он жилүүд байсан ажээ. Амагаев МАХН-ын IV их хурлын (IX сарын 23-наас – 1925 оны X сарын 2-ныг хүртэл) үйл ажиллагаанд Коминтерний бүрэн эрхт төлөөлөгчийн хувиар гар бие оролцжээ. Их хурал 1925 оны 3-р сарын Бүгд хурал дээр Рыскуловын оролцоотойгоор² хэлэлцэгдсэн, намын шинэ дүрэм болон түр мөрийн хөтөлбөрийг баталсан ажээ. Амагаев нь их хурал дээр Коминтерний Гүйцэтгэх Хорооноос намын мөрийн хөтөлбөрийн төслийн талаар ирүүлсэн үндэслэлийн талаар үг хэлсэн байна. Тэр монгол угсаат овог аймгуудыг чөлөөлөх тэмцэлд дэмжлэг үзүүлэх тухай заалтыг намын мөрийн хөтөлбөрөөс хасахыг санал болгосон байна. Тэр үүнийгээ батлах даа, энэ талаар тусгайлан зүйл болгон дурьдах нь илүүц бөгөөд учир нь, ер нь зөвхөн монгол угсаат аймгуудыг хувьсгалт тэмцэлд нь дэмжээд зогсохгүй, мөн үлдсэн дарлагдсан бусад ард түмнүүдийн тэмцлийг дэмжих учиртай хэмээж байжээ. Энэ зүйлийн үндсэн санаа нь, Халхыг тойруулан монгол угсаатныг нэгтгэх нь үндсэн зорилго хэмээн гуйвуулсанд байгаад оршино гэжээ. Энэ нь панмонголизмд хэлбийж буй буруу, хор уршигтай бөгөөд аюултай хэлбэрэл мөн...” хэмээн үзэж байв². Урианхайн асуудлын талаар тэр дурьдах

² Ичинноров С., Пэлжидийн Гэндэн., УБ., 1994., Үзэл баримтлал. Үйл ажиллагаа., 11-12 дахи тал..

¹ С.К.Роцин., “М.И.Амагаев: годы в Монголии”, “Восток”, Москва., 2000.

² Рыскулов Турар Рыскулович - Коминтерний Монгол дахи анхны төлөөлөгчөөр 1924-1925 онд ажиллаж асан – Г.А.

² С.К.Роцин., “М.И.Амагаев: годы в Монголии”, “Восток”, Москва., 2000.

даа, урианхайчуудад монголчууд, үндэсний тусгаар тогтнолоо олоход нь ямарваа нэгэн дарамт шахалт үзүүлэх учиргүй хэмээн хэлсэн байна. Их хурлын төлөөлөгчид Коминтернийхний хүсэлтийг тэр бүр дуртай дэмжин хүлээн авсангүй бололтой бөгөөд түүний төлөөлөгчийн баримт нотолгоонуудтай саналыг хүлээн зөвшөөрөхөд хүрсэн байна.

XII сард МАХН-ын ТХ-ны дарга Ц.Дамбадорж болон М.И.Амагаев нар Москва руу явсан бөгөөд 1926 оны 1-р сарын эхээр Коминтерний Гүйцэтгэх Хорооны хуралд их хурлын үр дүнгийн талаар ба ТХ-ны үйл ажиллагааны тухай тайлан илтгэл тавьсан байна. Тавьсан илтгэлүүдтэй холбогдуулан тогтоол гаргасан бөгөөд маш аядуу зөөлөн аястай тогтоол шийдвэр байсан ба ямар нэгэн өрнөлийг угтан зөгнөсөнгүй гэлтэй. 1926 онд өмнөх он жилүүдийн улс төрийн чиг шугам үргэлжилсэн байна. Хэрвээ хүсэх ахул “барууны аюул заналын” жишээг захаас аван олох л байлаа. Тухайлбал, “баяжигтун” хэмээх лоозон байв.

Мөн лам агсдын болон феодал агсадын талаар харьцангуй тууштай хатуу бус бодлого баримталж асан явдал, “Нармай монгол”-ын үзэл санаа, зөвлөлтийн зарим мэргэжилтнүүдийн илтээр дургүйцсэн явдлууд, “гадаадынхантай” тэр бүр хүсээд байхааргүй харилцаа өргөтгөн тогтоож эхэлсэн зэрэг явдлуудыг нэрлэж ч болох байжээ... Ямар нэгэн чиглэлийн хувьд сэтгэл ханамжгүй байдал хоёр талын хамтын ажиллагаанд, /хэлбэрт, түүний арга хэлбэр болон арга барилд/ улам ч тод томруунаар харагдах болсон байна. Гэхдээ 1926 онд үүнд онцгой ач холбогдол өгсөнгүй. Хоёр тал асуудлыг хурцатган гүнзгийрүүлэхийг хүссэнгүй. Улс орны байдал төлөв харьцангуй таатай байсан бөгөөд “баруун” зүг хэлбийх талаар яриад ч хэрэггүй байжээ. Үүнийг (1926 оны IX сарын 26-наас – X сарын 4-нд хуралдсан) намын 5-р их хурлын үйл явц нотлон харуулж буй юм. Уг хурлаар намын болон төрийн байгуулалтын талаар ээлжит зорилтуудыг шийдвэрлэсэн юм. Их хурлын уур амьсгалыг Ц.Дамбадоржийн хэлсэнчилэн : “...Энэхүү цаг хугацаанд ялангуяа, дээд феодалууд хүч байхаа нэгэнт больж, намын эсрэг тэмцэх чадваргүй болсон юм. Хуучны дээд толгой лам нар – тэд бол улс төрийн үхдэлүүд мөн” хэмээн хэлсэн ажээ. Хожим хойно энэ үгийн утгыг мушгин гуйвуулж, намын удирдлагаас хувьсгалын эсэргүү хүчнийг дутуу үнэлсэн, баруун тийш гуйвсан явдал мөн хэмээн гэрч болгосон байна. Гэхдээ тухайн үед, энэ хэллэгийг тийм ч хурц бус хүлээн авч байсан бөгөөд харин нам болон төрийн хүч хуучны феодал агсдаас илүү их боломжтой бөгөөд харин тэд бол өөрсдийн улс төрийн байр сууриа бодитойгоор алдсан байсан хэмээн С.К.Рощин тэмдэглэсэн нь буй.

М.И.Амагаев өөрийн Коминтернд илгээсэн зүйлдээ “намын их хурал ... идэвхитэй болж өнгөрсөн. Ерөнхий сэтгэгдэл гэвэл, хамгийн таатай бөгөөд хөдөөгийнхний идэвхи өрнөж буй. Их хурал үндсэн асуудлаар түүнтэй (Ц.Дамбадоржтой –зох.) болон ТХ-той санал бүрэн нэгдмэл байгаа...” гэсэн нь буй ажээ. Байдал 1926 онд эрс эргэсэн юм. Их хурлын дараа Амагаев Москва руу явж, түүний илтгэлийн дагуу Коминтерний Алс дорнодын нарийн бичгийн дарга нарын газар монголын асуудлаар ээлжит шийдвэр бүхүй тогтоолоо

гаргасан ажээ. Тэр нь уламжлалт арга маягаар бүрдүүлсэн байсан бөгөөд ямар нэгэн онц санаанд оромгүй зүйлүүд агуулаагүй байлаа. Гэхдээ энэ удаа тэр нь л Монголд ил тод дургуйцэл болон эсэргүүцэлтэй тулгарчээ. МАХН-ын ТХ-нд тогтоолын төслийг ширүүн байдалд авч хэлэлцэв. Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ц.Жамцарано болон бусад нөхдүүд түүнийг эрс шүүмжилсэн билээ. Ялангуяа, ТХ-нд “олонхи болон цөөнхи” байх тухай¹, лам нарын тухай асуудлууд, “баяжигтун” лоозонгийн тухай асуудал, хөдөөгийн идэвхитнүүдийг ашиглах тухай асуудал, Нармай Монголын чиг хандлагын тухай, японы дипломатуудтай харилцах талаар, зөвлөлтийн зааварлагч нарын талаархи зүйлээр ихэд маргалдсан байна. Гэхдээ мөн тогтоолыг дэмжсэн талын хүмүүс ч байсан юм, тухайлбал : “...П.Гэндэн, болон бусад нөхдүүд зүүний, хөдөөгийн сөрөг хүчнийхэн тогтоолыг зөв зүйтэй хэмээн үзэж байлаа. Эцэст нь, ТХ уг тогтоолыг анхаарал даа авсаныг мэдэгдэж, Москва руу төлөөлөгчидийг холбогдох тайлбартайгаар илгээхээр шийдвэрлэсэн байна. МАХН-ын удирдлага яагаад Коминтерний Гүйцэтгэх Хороотой тогтоолтой холбоотойгоор харилцаагаа хурцатгах нь зүйтэй хэмээн үзсэн бэ? Магадгүй үндэсний ардчилсан үзэлтнүүд шийдвэртэй алхам хийх цаг нь болсон хэмээн үзсэн ч байж болох талтай ...магадгүй өөрийнхөө байр суурийг зарчмын асуудлуудаар хамгаалах нь зөв бөгөөд улс төрийн биеэ даасан шийдвэр гаргах эрхээ хамгаалах нь зүйтэй хэмээн үзсэн болов уу ? Чухал хүчин зүйлийн нэг нь, намын удирдлага болон ерөнхий сайд Б.Цэрэндоржийн үйл ажиллагааных нь нэгдмэл байдлыг, үндэсний сэргэн мандалтын болон зөвшилцөл/эвсэл/-ийн үндсэн дээр ханган бэхжүүлэх явдал мөн гэж үзэж байлаа.

Монголын төлөөлөгчид (МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Г.Гэлэгсэнгэ, МАХН-ын ТХ-ны хэлтсийн эрхлэгч Б.Дугаржав) М.И.Амагаевын хамтаар Москвад 1927 оны 5-р сард хүрэлцэн ирсэн билээ. Монголын төлөөлөгчид Коминтерний Гүйцэтгэх Хороонд МАХН-ын ТХ-ны уг тогтоолын төслийн талаархи байр суурийг илэрхийлсэн бөгөөд Москвад орон нутгийн ба Монголын онцлог байдлыг харгалзан үзэхгүй байна хэмээн ёгтлон /битүү утгатай/ сануулсан ажээ. МАХН-ын ТХ нь их хурлын шийдвэрийн дагуу өөрийн ажлыг явуулж байгаа хэмээв. Коминтернд монголын талыг “баруун” тийш улам цаашлан хэлбийж буй хэрэг хэмээн үзсэн бөгөөд өөр хоорондын харилцаанд “хэвийн бус” шинэ байдал илрэн гарлаа гэж дүгнэсэн байна. Гэхдээ л 1927 онд эрүүл саруул ухаан ялан дийлж байлаа. Ер нь тэгэхэд Москвад Монголд болж буй үйл явдлын талаар нэгдмэл байр суурь байсангүй гэлтэй. Хэт хувьсгалчирхах үзэл сурталчилсан арга барил давамгайлж байсан ч, мөн намын дотоод дахи тэмцлийг хиймлээр өдөөхөд чиглэгдсэн арга ч мөн байсан юм. Мөн үүний хамт илүү бодож боловсруулсан, уул суурьтай, зөвшилцөл болон эв найрыг эрхэмлэхэд чиглэгдсэн (Бухарин нарын – зох.) арга ч мөн байжээ. Энэ бүхэн шууд л М.И.Амагаевын үйл ажилд нөлөөлсөн бизээ. 5-р сард Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар зүүний бүлэглэлийг бүхий л талаар дэмжих чиг шугам баримтлах тухай, “баруунтан” нарыг удахгүй болох 6-р их хурал дээр тусгаарлаж, мөн бут цохих тухай

¹ БХК/БН-ын жишгээр “фракц”-ийн тухай асуудал сөхөгдөн тавигдах болж эхэлсэн – Г.А.

чиглэлийг дэвшүүлэн тавьж байсан юм. Гэтэл их хурлын өмнөхөн л, Коминтерний Гүйцэтгэх Хорооны чиг шугам эрс өөрчлөгдөж, А.В.Шотман шинэ зааварчилгааг авчирсан бөгөөд – статус-кво-г хадгалах тухай, эв нэгдлийг хангах тухай, “баруунтан” нарын эсрэг тэмцлийг өрнүүлэхгүй байх тухай зааврыг өгсөн байна. Амагаев хүнд бэрх байдалд орсон байна. Их хурал хуралдах хүртэл 5-р сарын хатуу чиг шугамыг баримталж байсан тэрвээр, москлагийнхны нарийн ширийн зүйлүүдийг сонсож мэдээгүй ч байсан байж болох талтай. Мөн Шотманыг ирэхтэй холбоотойгоор шинэ эргэлтийн шинжтэй бодлого буй болно чинээ бодоогүй байсан гэлтэй. Тэр эрс өөрчлөлт хийх чадвар мөхөс байлаа, нөгөөтэйгүүр, мөн урьд өмнөх чиг шугамыг нь үргэлжлүүлэн, түүнийг нь л зөв зүйтэй хэмээн итгэсэн хэвээр байсан болтой. Тиймээс ч, тэр “баруунтан” бут цохигдох нь тодорхой хэмээн бодож байжээ. Гэтэл бүх зүйл эсрэгээр эргэжээ. 6-р (1927 оны 10-р сарын 22-ноос – 10-р сарын 5-ныг хүртэл) их хурал дээр хурц тэмцэл өрнөсөнгүй. А.В.Шотман бүх талаар хоёр талыг (МАХН-ын ТХ-ны “баруунтан” болон “зүүнтэн”-ий бүлэг – зох.) эвлэрүүлэхийн төлөө, зөвшилцөл болон нэгдмэл байдалд хүргэхийн тулд, дэмжлэг үзүүлж иржээ. Их хурал харьцангуй тайван болж өнгөрсөн, үндэсний ардчилсан талынхан удирдах албан тушаалуудаа хэвээр хадгалан үлджээ. А.В.Шотманы хэлсэнчлэн : “Их хурлын өмнөхөн оршиж байсан зөрчил цаг үеэ өнгөрөөсөн байсан, энэ бүхэн нь санал нэгтэй баталсан тогтоол шийдвэрүүд болон удирдлагын сонгох ажлын үеэр илэрч байлаа” гэжээ. М.И.Амагаев их хурлын үйл явцыг өөрөөр харсан бөгөөд дүгнэж байжээ.

Тэр өөрийн бухимдлыг нуугаагүй юм. Амагаев үзэх дээ, Коминтерны Алс дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын зааварчилгаа – статус-кво-г хадгалж байх – гэсэн үүрэг чиглэл нь баруунтангуудад бодитойгоор дэмжлэг өгсөнтэй адил болж, барууны удирдлагын эсрэг бүрэлдэн буй болсон сөрөг хүчнийхнийг зохион байгуулалтгүй, эмх замбараагүй болгон хаяж, “хөдөө”-гийн зүүний бүлгийнхнийг зэвсэггүй болгосонтой ижил болсон байлаа ... бидний их хурал дээрхи үүрэг бодитойгоор гацахад хүргэсэн ба ... баруунтангууд урьдахасаа илүү хүчтэй ялагчид болон гарч ирцгээсэн юм...” гэжээ. 6-р их хурлын үр дүнгүүдийн нэг бол Коминтернээс МАХН-ын дэргэд суугаа төлөөлөгч М.И.Амагаев нь тодорхой зорилгогүй болсон гэлтэй. Түүний их хурал дээрхи үйл ажиллагаа Коминтерны Алс дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын шийдвэрүүдийн 5-р сарын үзэл санааны дор байсан бөгөөд энэ бүхэн нь их хурлын үр дүнтэй зөрчилдөж байсан нь тодорхой байсан юм. Их хурал өндөрлөсний дараахан нь л, 10-р сарын 6-нд Коминтерний Гүйцэтгэх Хороонд ЗХУ-ын Элчин Сайдын Яамнаас цахилгаан утас илгээсэн бөгөөд түүнд тэмдэглэсэнчилэн : “...намын сүүлчийн нөхцөл байдал, Дамбадорж Амагаевын хоорондын харилцаа хурцадсан ажээ” гэсэн нь буй. Дамбадорж Амагаевтай ажиллахад хэцүү байгаагаа асуудал болгон тавьсан байжээ. Коминтерны төлөөлөгчийг шинээр томилон, Амагаевыг хурдхан Москва руу дуудахаас өөр аргагүй болсон байлаа. МАХН-ын ТХ-ны дарга Ц.Дамбадорж Коминтерний Алс дорнодын нарийн бичгийн дарга нарын газар руу илгээсэн захиан даа дурьдсан нь : “...Коминтерний шийдвэрийг тайлбарлах хүртэл Амагаевтай харилцан уялдаатай ажиллаж ирсэн, ямар нэгэн зөрчил байгаагүй. Гэтэл сүүлийн үед тэр

бидний эсрэг дургүйцлээ чиглүүлэх болж, Гэндэн болон Бадрах нарыг өөртөө татаж, нөлөөн дөө оруулах болсон¹. Шалтгаан нь тодорхойгүй. Бид түүнтэй намын эгнээний нэгдэл нягтралыг бэхжүүлэхийн төлөө чиг шугамыг явуулж байсан ба эвдрэлцээнийг хүсээгүй. Магадгүй уг хүн маань хэт удаан Монголд суусантай ч холбоотой байж болох юм...?" хэмээн Ц.Дамбадорж бичсэн байна². Цааш нь тэрвээр Амагаевын ажлын арга барилын талаар шүүмжилсэн байна. Тэр намын гишүүдийн доторхи тэмцлийг дэгдээхийн төлөө байсан бөгөөд "Бид Коминтернээс бидний ажлыг дэмжсэн үнэлгээтэй байхад, албан ёсны төлөөлөгч нь өөр ямар нэгэн зүйл рүү тэмүүлээд байх нь, аяндаа баримжаагаа алдахад хүргэх юм" гэжээ. Амагаев /өөрөө/ цахилгаан утсаар мэдэгдэх дээ : "...Намайг Москва руу яаралтай буцахыг зөвшөөрнө үү, цаашид, энд байх нь миний хувьд агуулгагүй байна...". 11-р сарын сүүлчээр Амагаев Москва руу буцаж иржээ.

Т.Рыскуловын түүх өөр хувилбараар, арай өөр нөхцөлд - дахин давтагдсан бөгөөд, мөн чанар эгээ адил байна : Коминтерны төлөөлөгч өөрийн бус шалтгаанаар монголын удирдлагын шаардлагаар Монголыг орхин явахаас өөр аргагүй болсон байлаа.

1928 онд Амагаев М.И. Москвад Коминтерны аппаратад ажиллах болсон байв. Зөвлөлтийн болон Коминтерний удирдах хүрээнийхний тактик нь энэ үед хуучин 1927 оны 5-р сарын удирдамжид буцаж шилжсэн байсан гэлтэй. Өөрөөр хэлбэл, "зүүний" сөрөг хүчнийг дэмжсэн тал руу баримжаалсан, баруунтныг бут цохих байр суурь баримтлах болсон юм.

Үүнд С.К.Рощины үзэж байгаагаар бол МАХН-ын удирдлагын байр суурь нөлөөлөх хүчин зүйл болсон байсан нь, намын 6-р их хурал дээр өөрийн хүч чадлыг мэдэрсэн тэд сөрөг хүчнийг дарамтлах нь ихсэж, түүний удирдагчидыг залхаан цээрлүүлэх тал руу хандсан байна. Энэ тал дээр судлаачминий бие зарим талаар Рощины саналыг үгүйсгэж болохгүй буй заа хэмээн үзэж буй ... Үнэхээр ч, зарим талаар "Хүрээхэн" гэгдэгсэдийн баримталж байсан үйл ажиллагаанд "репрессия" буюу "залхаан цээрлүүлэх" чиг хандлага руу хандах талтай болсон гэлтэй ...

Үүний хамт мөн хамгийн гол нь Бүх Холбоотын Коммунист /большевик/ Намын болон Коминтерний зүгээс өөрсдийнхөө "барууны" нугалаатантай хийх тэмцлийг чангатгах тухай ЗХУ-д болон Коминтерны секцүүдэд хэрэгжүүлж асан ерөнхий нөхцөл байдалтай холбоотой байсан билээ... Чухам энэ л БНМАУ дахи нөхцөл байдлыг субъектив байр сууринаас хандаж дүгнэх нөхцлийг бүрдүүлсэн, зүүний догматик, хүчирхийлсэн арга барил нь аядуу зөөлөн, үр бүтээлтэй аргаас давамгайлахад хүргэсэн бололтой.

Ц.Дамбадорж Москвад 1928 оны хавар-зун хэлэлцээ явуулсан нь эерэг үр дүнд хүргэсэнгүй. IX сарын 14-нд Коминтерний Улс Төрийн Нарийн Бичгийн Дарга Нарын Газар МАХН-ын ТХ-г эрс шүүмжилсэн тогтоол шийдвэрийг хүлээн авсан ба Улаанбаатараас Коминтерний албан ёсны байнгын төлөөлөгчийг татсанаа зарласан. Тогтоолын агуулга нь тодорхой байсан : "...баруунтаны"

¹ Ер нь П.Гэндэн, Ө.Бадрах нарын "хөдөө"-гийнхэн чухамхүү аль 1926 оноос эхлэн Ц.Дамбадорж нарын зэрэг "Хүрээ"-нийхэн гэгдэгсэдийн эсрэг зохион байгуулалттай болсон байсан гэлтэй ... - Г.А.

² С.К.Рощин., "М.И.Амагаев: годы в Монголии", "Восток", Москва., 2000.

удирдлага засгийн эрхэнд үлдсэн, үүнээс урган гарах үр дагавартайгаа хамт, МАХН-тай Коминтерний харилцаа муудах нь зайлшигүй болсон” гэжээ. Нэгэн зэрэг МАХН-ын VII их хурал дээр Коминтерний төлөөлөгчдийн үйл ажиллагааны удирдамжийг баталсан байсан.

Зааварчилгаа байр сууриа өөрчлөн залахад хангалттай өргөн боломжийг олгож байсан бөгөөд учир нь төлөөгчдийн өмнө эрх мэдлийг “зүүнтэн” нарын гарт бүрэн дүүрэн шилжүүлэх асуудал яригдаж байсангүй гэлтэй. Мөн “үндэсний” ардчилсан хүчинтэй эвсэх боломжийг хүлээн зөвшөөрч байлаа. Голлох үгийг хэлэх эрх Б.Шмеральд оногдож байв. Түүнийг ЗХУ-ын Элчин сайд А.Я.Охтин дэмжиж байжээ. М.И.Амагаевын үүрэг ч үүнд багагүй байсан бололтой. Б.Шмераль өөрийн гол эксперт буюу шинжээч болох Амагаевын байр суурь, санал сэтгэгдэлд юу юунаас илүү найдаж, даган сонсож байсан ажээ. 1927 оны нэгэн адил “зүүнтэн” буюу “хөдөө”-гийнхэний талд баттай зогсож байсан байна. Тэрвээр “баруунтан” нарыг бут цохихоор онилж байжээ. Гэхдээ “зүүнтэн” нарын лидерүүдийн бололцоонд тэгтлээ их найдаад байсангүй. XI сарын 25-нд элчин төлөөлөгчийн газар болсон зөвлөлгөөн дээр тэрвээр хэлэх дээ : “...Би сөрөг хүчний хэнд нь ч бүрэн дүүрэн итгэхгүй байгаа. Ирээдүйд хаашаа явах нь тун тодорхойгүй байгаа. Тэд хангалттай өсөн бэхжээгүй л байна” гэжээ. Шмераль түүнтэй санал нийлэхгүй байв. “Бид ирээгүй бол зүүнтэн нарын олонх нь “баруун” тийш эргэсэн байх байсан юм. Мөн тэр тэмдэглэн хэлснээр : “...Улс төрийн хатуу гарт байгаа, хангалттай боловсролтой, хатуу байр суурь бүхүй, гэхдээ боловсрол сайнгүй тийм хүмүүс байх ёстой” гэжээ. Москва руу буцах даа төлөөлөгчдийн бүрэлдхүүн тодорхой тайланг тавьсан байна. Түүнд дурьдах даа : “зүүний” хүчний ялалтын эерэг талыг дурьдаад тэдэнд туслах нь зайлшигүйг онцлон тэмдэглэж байв. Амагаевын хэлсэнээр бол : “... зүүн удирдлага практик ажил явуулах даа сул дорой” гэсэн байв. Амагаевын санал сэтгэгдэл болон үзэл бодлын талаар тухайн цаг үед жишээ нь, түүний хэлсэн үгнээс дүгнэж болох талтай. “Үндэсний хөрөнгөтөн /анги/ ... аажим аажмаар удирдан чиглүүлэх үүрэг гүйцэтгэх болж буй бөгөөд ...VII их хурал дээр хоёр чиг шугам өрсөлдөж байсан ... хөрөнгөт нийгэм үү, нийгэм журам уу ...”, “Үзэл сурталын хүмүүжил одооноос марксизм-ленинизмын үзэл санаан дор явагдах ёстой”, “Монгол оронд ойрын ирээдүйд баруун талаас л тэсрэлтийг хүлээхээс, зүүн талаас лав биш” гэсэн байх ажээ.

1929 оны III сарын 1-нд Коминтерний Гүйцэтгэх Хорооны нарийн бичгийн дарга нарын газар монголын асуудлаар шинэ тогтоол гаргасан. Уг тогтоол хангалттай болгоомжтой байсан бөгөөд эрс шинэчлэлийн өөрчлөлтийн утга санааг өөртөө агуулаагүй байжээ. “Хөрөнгөтөн-феодалууд болон лам нарын эдийн засгийн болон улс төрийн суурийг нь” хөндөх тухай нам гүм ёжлолыг янз бүрээр л тайлбарлаж болох байв. Хамгийн гол нь намын VII их хурлын шийдвэрийг хэрэгжүүлж буй зүүнтэн нарын удирдлагыг шийдвэртэйгээр дэмжиж байгаад л гол учир нь оршиж байлаа.

1928 оны дунд үе хүртэл Коммунист Интернационалын болон МАХН-ын ТХ-ны хооронд оршиж ирсэн урьдын хамтын ажиллагаа бүрэн хэмжээнд сэргэж ирсэн байна. МАХН-ын ТХ-ны шинэ удирдлага Коминтерны Гүйцэтгэх Хорооны удирдлагад хандаж Улаанбаатарт М.И.Амагаевыг Коминтерний Бүрэн Эрхт

төлөөлөгчөөр дахин ирүүлэхийг хүсэж байлаа. Түүний зүүнтэн нарыг дэмжиж ирсэн тууштай байр суурийг “хөдөө”-гийнхэн буюу “зүүнтэн” нарын бүлэг зүй ёсоор үнэлэн дүгнэж байсан ажээ. 1929 оны 3-р сарын сүүлээр Амагаев Улаанбаатарт дахин ирж ажиллах болсон юм. Бүрэн эрхт төлөөлөгч А.Я.Охтины хамт тэр ЗСБНХУ болон БНМАУ-ын харилцаа, хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг тохиролцсон өргөн цар хүрээтэй Хэлэлцээрийн эхийг бэлтгэх ажилд шилжин орсон байлаа.

Урт удаан хялбар бус хэлэлцээ ба тодотголын үр дүнд VI сарын 27-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан байна. Хэлэлцээ нь хамтын ажиллагааны үндсэн салбаруудыг хамарч байсан бөгөөд түүний шинж чанаруудад шинэ санаануудыг оруулж ирсэн юм. Харилцаа урьд өмнөхөөс илүү ойр нягт болж ирсэн бөгөөд илүү ойр дотно, бие биен дээ итгсэн, “ах дүү”-гийн ёсны шинжтэй болжээ¹.

Амагаевын өөр нэгэн үйл хэрэг бол – ТХ-нд өдөр тутмын туслалцаа үзүүлэх явдал байсан. Намын VII их хурлын үзэл санааны дагуу хэт зүүний эрс өөрчлөлт бүхүй шинэчлэлийг хийхэд идэвхитэй дэмжлэг үзүүлэх явдал байлаа. Анхны сэтгэгдэл таатай байжээ.

1929 оны V сарын 12-нд тэр ТХ-нд зарчмын шинжтэй зөрөлдөөн байхгүй болно гэжээ. Ажил хэргийн шинжтэй санал зөрөх явдал бол байсан гэжээ. Бүхэл дээ одоо цагт бид бүхэн бүх зүйл хангалттай хэмээн дүгнэж байна гэжээ. Тэр тэмдэглэснээр бол – “...III сарын Коминтерний тогтоол шийдвэрийг хөдөлшгүйгээр хэрэгжүүлэхээр санал нэгтэй хүлээн авсан хэмээжээ. ТХ-ны V сарын бүгд хурлын дараа түүний дараа залгасан Монголын засгийн газрын тогтоол шийдвэрүүдээр феодал агсдын мал, хөрөнгийг хураан авах, ардын аж ахуйг хоршоолох кампанит ажлууд өрнөж эхэлсэн¹.

Тэр нь тун чиг бат бэх бус бөгөөд тэр бүхэн нэгэн зэрэг хослон гүйцэтгэгдэж байсан ба – хураагдсан өмч хөрөнгө ихэнх нь хамтралуудад тараагдаж, гэсэн хэдий ч ямар ч үед тэр нь тарах боломжтой байсан. Монголын хөдөө нутагт ямар их будлиан тарьж байсан нь тодорхой. Эсэргүүцэл, ил тод тэмцэл удаан хүлээлгэсэнгүй. Москвад өмч хөрөнгийг хураах болон хамтралжуулах кампанит ажлыг эхний үед зарчмын хувьд л зөвшөөрч байсан. Харин өөрчлөлт бүрэн явагдаж эхлэх үед Москвад санаа зовних шинж тэмдэг гаргах болсон гэж оросын судлаач өгүүлсэн байдаг.

X сарын 6-нд коминтерний Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газар Амагаевт цахилган утас илгээсэн. Түүнд өгүүлсэнээр “Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газар эрх мэдэл бүхүй ноёд ба хутагт нарын өмч хөрөнгийг хураах хууль нь Коминтерний Гүйцэтгэх Хорооны удирдамж заавар, шийдвэр ирэхийн өмнөхөн явагдсан байсныг тэмдэглэж буй. Өмч хөрөнгө хураавал зохих хүмүүсийн зэрэглэлийн жагсаалтын хамрах хүрээг МАХН-ын ТХ-ны өмнөх шийдвэрээс харьцангуй хүчтэй өргөтгөсөн байсан...”. Цааш нь албадан хураах хүрээг хязгаарлаж, зөвхөн “хамгийн харгис бөгөөд хувьсгалын эсэргүү дээд

¹ монгол-зөвлөлтийн ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа гэх нэр томьёо ойлголт чухамхүү энэ түүхэн цаг үеэс үүсэн буй болсон бус уу ... - Г.А.

¹ энэ бүхэн нь “зүүний” гэгдэх нугалаа завхралын уг сурвалж, эх үндэс нь болжээ - Г.А.

хэсгийг” хамрах хэрэгтэй гэжээ. Коминтерний дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын X сарын 10-ны цахилгаан утсанд түгшүүр бүхүй байх агаад түүнд дурьдсанаар бол – “Манай X сарын 6-ны өдрийн цахилгаан утсыг авсан уу? Өмч хөрөнгийг нь хураах хүмүүсийн хүрээг хязгаарлах тухай манай зөвлөлгөөг хэрхэн хэрэгжүүлж байна вэ ? Хөрөнгө хураах ажил явагдаж байна уу ? Яаралтай хариулна уу” гэсэн байх юм.

Үүнээс үзэх ахул тэр сард Москвад хангалттай болгоомжтой байсан ажээ. Монголд эхлээд байсан өмч хөрөнгө хураах болон хамтралжуулах кампанит ажилд Москва болгоомжлохгүй байж чадахгүй байжээ. Москвад энэ чиглэлд хийгдэж байсан илүү аядуу тайван бөгөөд ухаалаг алхамуудад бүрэн дүүрэн ойлгож хандаж байсан хэмээн үзэж болох талтай юм. Магадгүй “зүүнтэний” удирдлагын олонхи болон Амагаев хэт идэвхи гарган, хэтрүүлсэн байсан бололтой. “Яравчлахыг” түргэвчлэн Зөвлөлт Холбоот Улсаас хоцрохгүйг хичээн, үнэн хэрэгтэй тийм сайхан байгаагүй бодит байдлыг сайн сайхнаар дүрслэн будаж, мэдээлж байсан ажээ.

10-р сарын 13-нд Амагаев Коминтерний Гүйцэтгэх Хороонд цахилгаан утас илгээсэн /хуулбарыг нь В.М.Молотовт тэр дор нь илгээсэн байв/. “Та нарын /Улс Төрийн Товчооноос дэмжигдсэн, Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газрын удирдамж/ зааварчилгааг ТХ-нд өгсөн, тэд үйл ажиллагаан даа удирдлага болгож буй.

... Өмч хөрөнгө хураах ажил ер нь сайн явагдаж буй. Хүн ам өмч хураах ажлыг идэвхитэй дэмжиж буй. ...Газар дээр нь хүн амын өөрсдийнх нь санал санаачлагаар хамтралуудыг байгуулж байна ...” гэсэн байжээ.

Амагаев Москвад эргэж ирээд /X сарын сүүлээр/ нөхцөл байдлыг яг л иймэрхүү маягаар үнэлж дүгнэж байсан. X сарын 30-ны захиан даа тэр ялангуяа, “Хамтралыг зохион байгуулах асуудал нь өмч хөрөнгө хураах явдалтай хамт шамдуулж хурдасгасан байсан ...хүн ам газар дээрээ хамтралуудыг зохион байгуулах ажилд харьцангуй дэмжиж байсан” гэсэн нь буй. Мөн түүнчлэн “зарим нэгэн районд хүн ам нь хамтралууд байгуулах асуудалд тэр бүр дуртай бус байсан” гэжээ. Хамтралууд болон улсын сангийн аж ахуйнууд нь манай зүгээс илүү тус дэмжлэгтэйгээр ажиллаж чадах юм гэсэн нь буй ажээ. Амагаев яагаад хамгийн их ажил, ачаалалтай байх үе дээ Москвад буцаж ирсэн бэ гэдэг асуудал гарч ирж болох. Тэр Монголд ердөө л 7-хон сар ажилласан байлаа.

А.Амар ерөнхий сайд өмч хөрөнгө хураах болон хамтрал байгуулах асуудалд дурамжхан хандаж байсан ажээ. МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга П.Гэндэнгийн хувьд хөдөө ардын аж ахуйтнуудын дунд төрж өссөн түүнд эргэлзээ хийгээд түгшүүр тэр үеэс төрж эхэлсэн бололтой.

1929 оны зун ба намар Амагаев амжилтад бүрэн итгэж ажиллаж байсан бөгөөд илүү шийдмэг байжээ. Энэ үндсэн дээр тэр болон Гэндэнгийн хооронд зөрчил үүссэн байжээ. Тэр монголын бусад удирдагч нарт илүү дотно хандаж байсан, ТХ-ны нарийн бичгийн дарга Ө.Бадрах байлаа. Тэр нь илүү үгэнд оромтгой, эелдэг дуулгавартай хүн байсан гэлтэй ажээ. Мөн тэр илүү “эрс радикал /шинэчлэл/” байр суурь баримталж байсан бололтой.

VII сарын 5-нд П.Гэндэн Коминтерний дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын удирдагч П.А.Мифэд хандаж захиа бичсэн байна. Тэр МАХН-ын

ТХ-ны доторхи санал бодлын зөрөлдөөний талаар дурьдаад, мөн М.И.Амагаевын үйл ажиллагааны талаар өөрийн байр суурийг илэрхийлжээ. "Коминтерний бүрэн эрхт төлөөлөгч Амуга Бадрахын талыг хэт баримталж, зүүнтнүүдийг илт дэмжиж, өөрийн байр суурийг хувийн ноёрхолыг тогтоохын тулд ашиглаж байгаа бөгөөд ТХ-нд санал зөрөлдөөнийг дэвэргэж буй. Дотоодын жижиг сажиг асуудлуудад оролцож байна..." гэсэн байна.

Москвад Гэндэнгийн саналд онцгой ач холбогдол өгсөн байна. VII сарын 25-нд Миф Амагаевт цахилгаан илгээж – "... Бидний хүлээн авсан мэдээгээр Гэндэн Бадрах нарын хоорондын харилцаа хэвийн бус бололтой. Энэ хоёр бүлгийн бүрэн зохицолдоон болон хамтран ажилласан явдлыг хангасан байх шаардлагатай байна. Танд дотоодын жижиг сажиг асуудалд нь орооцолдох хэрэг үгүй болно. Таны чиг шугам хэт захиргаадсан, заримыг нь халамжилсан, Гэндэнгийн бүлгийг үгүйсгэсэн байдалтай хэмээх шүүмжилэлийг хэрхэн хүлээн зөвшөөрөх вэ" гэжээ.

Амагаев болон Гэндэн нарын хамтын ажиллагаа мухардалд орсон явдал нь түүний хугацаанаасаа өмнө буцах эхний шалтаг шалтгаан нь болжээ. Москвад Коминтерний бүрэн эрхт төлөөлөгч болон монголын удирдагч нарын хооронд харьцааг хурцатгах сонирхол байсангүй ажээ. Мөн Монголын тэргүүлэх удирдагч нарын хооронд санал зөрөлдөөн хүчтэй болохоос болгоомжилж байлаа. Энэ бүхэн нь явуулж буй чиг шугамд аюул учруулж болзошгүй байв. Тийм ч учраас Амагаевыг дуудаж ирүүлэх нь Монголын удирдлагын доторхи нөхцөл байдлыг тогтвортой болгох байсан бөгөөд ЗХУ болон Коминтернтэй Монгол Улсын тогтоосон хэлхээ холбоог хөгжүүлэх явдалд тус дөхөм болно хэмээн тооцоолж байжээ.

Нөгөө талаар М.И.Амагаев ба ЗХУ-ын Элчин сайд А.Я.Охтин нарын хооронд монголын тулгамдсан асуудлуудын талаар хандах хандлагад ялгаа бүхүй хандах байр суурь анзаарагдаж байлаа. Элчин сайд илүү бодож боловсруулсан, ул суурьтай, аядуу зөөлөн, асуудалд илүү болгоомжтой байр суурь баримталсан байсан бол, Амагаев радикал байр суурь баримталж байжээ. Иймээс монголын удирдагч нарт хандах хандлага нь хоорон доо зөрж байсан бөгөөд Охтин Гэндэнг болон түүний бүлгийг дэмжиж байхад, Амагаевт Бадрахын бүлэг илүү ойр дотно байсан ажээ. Үүнээс үүдэн харилцан бие биенээ алдаа гаргасан хэмээн буруутган шүүмжилж байжээ.

Түүний орос хэл дээрхи намтарт өгүүлсэнчилэн : "...1929 онд алан хядлага, сүм хийдүүд хаагдсанаар бослого дэгдсэнтэй холбогдуулан хэт зүүнийүзэл гаргасантай нь холбогдуулан буруутгаж, нутаг буцаасан. 1930-1932 онуудад Коммунист Намын Дээд Сургуульд суралцажээ. Дорно дахины хөдөлмөрчдийн их сургуульд намын байгуулалтын тэнхимд багшлах болж, Москвагийн дорно дахины дээд сургуульд монгол ардын хувьсгалын түүхийн лекцийг унших болжээ. 1932 оны XI сард Намын дээд сургуулийн 3-р курсээсээ дуудагдаж, улмаар 1932 оны XII сараас дорно дахиныдээд сургуулийн ректороор томилогдон ажиллах болсон байна.Боловсрол багатай, дарангуй зан араншинтай Амагаев нь Ленинградын дээд сургуулийн профессоруудын дунд онцгой сэтгэгдэл төрүүлж чадаагүй юм. Гэхдээ америкийн нэрт монголч эрдэмтэн Н.Поппе Амагаевтай тэр сургуульд ажиллах үе дээ түүний итгэлийг

хүлээж илүү дотно нөхөрлөх болсноо дурсан санасан байдаг ажээ. Поппе бичсэнээр: "...Амагаев байгалиас заяасан хурц ухаан, улс төрийн алсын хараагаараа, мөн бусдаасаа өвөрмөц сэтгэлгээгээрээ бусдаас ялгардаг байлаа ..." гэжээ.

Нэг удаа Амагаев нь Поппетэй ярих үе дээ : "...Монголд манай ЗХУ-тайнэгэн адил улсын капитализм байгаа /буй/ бөгөөд..." Монголд нийгэм журам /социализм/ ч байхгүй, мөн нийгэм журамд шилжих шилжилтийн гэмээр нийгэм ч байхгүй юм¹ хэмээн хэлсэн ажээ. Энэ өвөрмөц дүгнэлт Поппег их л гайхшруулсан гэдэг. Гэсэн хэдий угийн үнэнч коммунистын хувьд намын бодлогыг тууштай хэрэгжүүлсэн ажээ.

1935 оны I сард "Ленинградын дорно дахины дээд сургуулийн сэхээтэн багш нарын муу таньж мэдсэний төлөө, мөн, амьдрал үйл ажиллагааг тодорхой бус удирдсан учир намын сахилга батын арга хэмжээ авахуулжээ". 1936 оны IV сараас Бүх Холбоотын Төвийн Гүйцэтгэх Хорооны үндэсний цөөнхийн дамжааны /курсийн/ захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон байна.

Амьдралынхаа сүүлийн жилүүдэд тэрбээр "Монгол орон дахи хувьсгалт хөдөлгөөний түүх" номоо бичиж байжээ.

...XX зууны 20-30-аад онуудын монголын нам, улсын түүхэнд арилшигүй, гэхдээ ноцтой гэмээр ул мөрөө үлдээсэн Орос, Буриад, Коминтерний зүтгэлтнүүдийн нэгэн болох М.И.Амагаевын намтар түүх зөрчил тэмцэл дүүрэн байлаа ...

Амагаевыг 1937 оны 9-р сарын 30-нд НКВД-гийнхэн баривчлан всан байна. Түүнийг ЗСБХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-ын 1а, 7, 11-ээр буруутган ялласан байна. ...Хожим Золбингийн Шижээгийн НКВД-д буюу ЗХУ-ын Дотоод Хэргийн Ардын Комиссириатын Газарт баригдаад нээсэн мөрдөн байцаалтын хавтаст хэрэг буюу "Дело Золбингийн Шижээ"-д бичсэнээс үзэх ахул "...Амагаевыг Миф, Кучумов, Черномордик болон Полонский нарын хамтаар Коминтерны дорнод секторт байгуулагдсан хэмээгдэх "троцкист"¹ байгууллагын идэвхитэн гишүүний нэгэн хэмээн буруутгасан нь буй ...Түүнийг эсэргүү үйл ажиллагааг идэвхитэй явуулж ирсэн хэмээсэн байлаа. ЗХУ-ын Дотоод Хэрийг Ардын Комиссириатын Газрын 1940 оны II сарын 19-ний тогтоолоор 8 жилээр яллан Коми –н Автономит Бүгд Найрамдах Улсын СевЖелДорЛага-ын 39-р цэгт ялаа эдлэх болж, хоригдож байх үе дээ 1944 оны VIII сарын 18-нд таалал төгсжээ. 1956 онд цагаадсан ажээ.

...Ийнхүү М.И.Амагаевын намтар түүхийн зарим хэсгээс товчхон дурьдахад ийм буюу ...

¹ Рорре. 1983.Р.140. /140 дэх тал/ - Г.А.

¹ зүүний байгууллага, сталины эсрэг чиг хандлага бүхүй хэмээн үзэж байжээ – Г.А.

Ном зүй :

1. Ариунболд. Г., "I Великий Народный Хурал и Өлзийтийн Бадрах" "Монгол Цэргийн Түүхэн Судлал", 2006.1.
2. Ариунболд. Г., "Шар Санжийн хэрэг", "Батлан Хамгаалах Судлал", 2007.
3. Ариунболд. Г., "Турар Рыскулович Рыскулов" – Г.Ариунболд., "Боловсролын Их Сургуулийн Эрдэм Шинжилгээний өгүүлэл", 2009. №
4. Ариунболд. Г., УБ., 1990., Дипломын ажил., МУИС.НУФ. Г.Ариунболд., "Вопросы оценки исторического места, оценки "левизны" в истории МНР". /Дипломная работа Монгольского Государственного Университета, Кафедра истории Монголии. Академия Наук МНР. Институт Истории. Сектор новейшей истории. Научный руководитель Ринчин Мунхдалайн. Доктор исторических наук. Ph.D. Директор Исследования Центром Политических Репрессии Комиссии Реабилитации Политически Репрессированных при Государственном Хурале Монголии.
5. Ариунболд Г., "Улзийтийн Бадрах – III съезд МНРП. /1924г./", Боловсролын Их Сургуулийн эрдэм шинжилгээний эмхтгэл., УБ., 2007.
6. Болдбаатар Ж., Түүх зулсан он жилүүдийн ойллого.УБ.I боть., 2003.
7. Болдбаатар Ж., Түүх зулсан он жилүүдийн ойллого.УБ.II боть., 2003.
8. Болдбаатар Чунтын. УБ. XX зууны Монголын улс төрийн зүтгэлтнүүд. УБ., 2004.
9. БНМАУ-ын түүх., История МНР., УБ., III.1969.
10. Болдбаатар Ч., /Монгольский Государственный Университет Образования/ - Об отношениях П.Гэндэна, У.Бадраха. Научная конференция посвящённая 110 летию со дня рождения Улзийтийна Бадраха в Убсанурском аймаке в июне 2005 г. Монголия.
11. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар их хурал. Дэлгэрэнгүй тайлан., УБ.,1984.
12. Борнеман, 1924. 468 дахи та. Егунов. Н.П. М.И. Амагаев. Улан-Удэ. 1974.
13. Бурятский РКМ., ГАРФ., Ф. 7668., оп.1., д.2895.
14. Дашдаваа Ч., Улаан түүх., УБ., 2003.
15. Дашдаваа Ч., Түүх. Соёл. Улс төр., УБ., 2005.
16. Дашдулам.С., Деятельность и концепции представителей левых сил в Монголии /1928-1932 гг./ Улан-Удэ .1998. Кандидатская диссертация исторических наук.
17. Дашдулам Дашдэлэгийн., Зүүнтний нэгэн удирдагч. Улаанбаатар. 1996.10.26., № 206-207 /1138,1139/.
18. Дашдулам. Д., "Хувь заяаны гунигт эрх". /"Трагический конец судьбы" статье о жизни и биографии У.Бадраха./, Засгийн газрын мэдээ. /"Новости правительства" – газета правительства Монголии./, 1995.08.17., № 103 (345).
19. Дашдаваа Чулууны., Политика и деятельность Коминтерна в отношении Монголии., УБ. 2002. Кандидатская диссертация исторических наук.

20. Монгол Улсын түүх. 5-р боть., УБ., 2004. История Монголии. УБ., 2004. 5 том.
21. Рощин С.К., "М.И.Амагаев: годы в Монголии", "Восток", 1997. №6, 43-52 дахи тал. Академия Наук РФ.,
22. Рощин.С.К., Политическая история Монголии /1921-1940/. Москва. 1999.
23. Рощин.С.К., Маршал Монголии. Х.Чойбалсан. Москва. 2005.
24. Рощин.С.К., Пэлжидийн Гэндэн. Восток. 2004. №.
25. Порре. 1983.Р.139, 140. Восток. 2004. №4. 116 дахи тал.
26. Современная Монголия // Жизнь Бурятии. 1924. № 2/3. С 6-9, Монголия на путях реформ // мөн тэнд. 1925. № 9/12. 4-10 дахи тал. /амуга/. Очередные задачи хозяйственной политики всвязи с денежной реформой // ХМ . 1926. №2. 1-7 дахи тал. К вопросу о путях и перспективах социально-экономического развития Монголии : (Из доклада тов. Амуга на 5-ом съезде МНРП) // Мөн тэнд, 1927. №1. 3-5 дахи тал. Пятилетний план развития народного хозяйства и задачи массовой школы. Верхнеудинск. 1930.